



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**МОНГОЛ УЛСЫН  
ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 5/2, Засгийн газрын IV байр, Утас: 263538,  
Факс: 31-27-98, E-mail: info@spc.gov.mn

2015. 04. 02 № 16/846


танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН Г  
ЗАХИРАЛ С.ЦАЦРАЛТ ТАНАА

Түүх соёлын дурсгал, үзмэр эд өлгийн зүйлийн дахин үнэлгээний дүнг батлах тухай Төрийн өмчийн хорооны 2015 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 122 дугаар тогтоолыг үүгээр хүргүүлж байна.

Заалт нэг бүрээр нь мөрдөн ажиллаж, биелэлтийг Төрийн өмчийн хороонд ирүүлнэ үү.

ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА



Ц.ОДМАА

C:\My Documents\Blank A5

1110904



МОНГОЛ УЛСЫН  
ТӨРИЙН СӨЛӨГЧИЙН ХОРООНЫ ТОГТООХ

2015 03

05

122

Түүх, соёлын дурсгал, үзмэр,  
эд өлгийн зүйлийн дахин  
үнэлгээний дүнг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2013 оны 38 дугаар тогтоослын 4 дэх заалт, Сангийн сайдын 2013 оны 140 дугаар тушаалаар баталсан "Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн үнэ тогтоох журам"-ын 2 дахь хэсгийн заалтыг тус тус үндэслэн Төрийн өмчийн хорооноос ТОГТООХ нь:

1. Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа эрхлэж байгаа нэгдүгээр хавсралтад заасан Богд хааны ордон музейн 16 ширхэг 767,477,330 /Долоон зуун жаран долоон сая дөрвөн зуун далан долоон мянга гурван зуун гуч/ төгрөгийн балансын үнэ бүхий үнэт зүйл дэх барилгыг дахин үнэлэхэд 774,077,330 /Долоон зуун далан дөрвөн сая далан долоон мянга гурван зуун гуч/ төгрөг болж, хоёрдугаар хавсралтад заасан Музейнүүдийн 21472 ширхэг 1,888,115,767 /Нэг тэрбум найман зуун наян найман сая нэг зуун арван таван мянга долоон зуун жаран долоо/ төгрөгийн балансын үнэ бүхий түүх соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийг дахин үнэлэхэд 19,730,708,115 /Арван есөн тэрбум долоон зуун гучин сая долоон зуун найман мянга нэг зуун арван тав/ төгрөг болж, нийт 17,849,192,348 /Арван долоон тэрбум найман зуун дөчин есөн сая нэг зуун ерэн хоёр мянга гурван зуун дөчин найм/ төгрөгөөр нэмэгдсэн тул үнийн зөрүүг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын дагуу дахин үнэлгээний нэмэгдэл данснаас холбогдох үндсэн хөрөнгийн дансны дебет дансанд бүртгэхийг Богд хааны ордон музей, Үлэг гүрвэлийн музей, Хөшөө цайдам музей, Монгол цэргийн музей, Улаанбаатар хотын музей, Төрийн түүхийн музейн удирдлагуудад тус тус зөвшөөрсүгэй.

2. Хавсралтад заасан хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэлд тусгахыг Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын эрхлэх ажлын хүрээний Богд хааны ордон музей, Үлэг гүрвэлийн музей, Хөшөө цайдам музей, Монгол цэргийн музей, Улаанбаатар хотын музей, Төрийн түүхийн музейн удирдлагуудад тус тус даалгасугай.

3. Энэ тогтоолын биелэлтийг 2015 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн хороонд ирүүлсүгэй.

00003+5

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, хяналтын газар /О.Сэр-Од/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НАНЗАДДОРЖ

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ц.ОДМАА

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ц.ОДМАА



Handwritten signature and official stamp of the State Registration, Usage, and Supervision Agency of the Republic of Mongolia.